

## МОНГОЛ, ОРОСЫН СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ АЛХМУУД

К.Дэмбэрэл\*

### Товч утга:

Энэхүү судалгааны материал нь 1991 оноос хойш Монгол, Оросын хооронд байгуулсан өндөр ач холбогдол бүхий 4 чухал баримт бичгүүдийг зүйл бүрээр задалж үзсэн. Эдгээр нь 1991 оны Найрамдал, хамтын ажиллагааны Тунхаглал, 1993 оны Монгол, Оросын найрамдлын Гэрээ, 2000 оны Улаанбаатарын Тунхаглал, 2006 оны Москвагийн Тунхаглалууд билээ. Энэ судалгаа нь баримт бичгүүдийг байгуулах үеийн хоёр орны дотоод эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлыг товч харьцуулан үзүүлсэн. Монгол, Оросын стратегийн түншлэлд чухал ач холбогдол бүхий эдгээр баримт бичгүүдийн талаар судлаачийн үнэлэлт, дүгнэлт гаргасан судалгааны ажил болно.

**Түлхүүр үгс** – “Найрамдал, хамтын ажиллагааны Тунхаглал”, “Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээ”, Монгол Улс, Оросын Холбооны Улс, “Улаанбаатарын тунхаглал”, “Москвагийн тунхаглал”

Сүүлийн 20 жилд Монгол, Оросын харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хүргэхэд чухал ач холбогдол бүхий 4 баримт бичгийг талууд соёрхон баталсан билээ. Энэхүү баримт бичигт 1991 оны 2 сарын 12-нд үзэглэсэн БНМАУ, ЗСБНХОУ-ын хоорондын хамтын ажиллагаа, сайн хөршийн тухай Тунхаглал, 1993 оны 1 сарын 20-нд байгуулсан Монгол улс, ОХУ-ын хоорондын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ, 2000 оны 11 сарын 13-нд байгуулсан Улаанбаатарын Тунхаглал, 2006 оны 12 сарын 8-нд байгуулсан Москвагийн Тунхаглал багтдаг. Эдгээр нь хоёр орны харилцааны

\*К.Дэмбэрэл – Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор (Ph.D)

үндсэн баримт бичиг төдийгүй стратегийн түншлэлийг тунхагласан баримт бичиг тул тус бүрд нь зүйл нь бүр чухал, тиймээс зүйл бүрээр нь задалж үзэх нь судлаачдын үүрэг билээ.

Энэ өгүүлэл нь сүүлийн 20 гаруй жилд хоёр улсын хооронд дээд хэмжээний уулзалтын үеэр байгуулсан “нэн” чухал баримт бичгүүдийг үзэглэх үеийн хоёр орны улс төр, нийгэм эдийн засгийн ерөнхий төлөвийг тоймлон, чухам ямар нөхцөлд баримт бичгүүд маань баталгаажсаныг үзүүлэх зорилготой судалгааны материал бөлгөө.

Аливаа гэрээ, хэлэлцээр нь тухайн асуудлыг хууль эрхийн хүрээнд баталгаажуулж буй зүйл. Монгол-Оросын харилцааны хувьд бол өнгөрсөн зуунд дээд хэмжээнд нэлээн олон тооны гэрээг байгуулсан. Эдгээр гэрээнүүд нь тухайн үеийн улс төр, нийгэм эдийн засгийн шаардлагаар бий болж байсан. Манай судлаачид алив нэг гэрээг байгуулангуут харилцаа шинэ шатанд гарлаа хэмээн ойлгож, бичиж ирсэн. Энэхүү өгүүлэлд хоёр орны харилцааг уламжлалт байдлаар бус арай өөр өнцгөөс харуулахыг зорилоо.

Олон улсын хоорондын хууль эрхзүйн баримт бичигт улсуудын бие даасан тэгш байдал, хүч үл хэрэглэх ба хүчээр түрэмгийлэхгүй байх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын бүрэн бүтэн байдал, маргааныг энхийн замаар зохицуулах, дотоод хэрэгт үл оролцох, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх, ард иргэд нь өөрсдийн хувь заяанд эзэн болох, улс хоорондын хамтын ажиллагааны тухай, олон улсад хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлэх гэсэн 10 зарчмыг мөрдлөг болгодог.

Шинэ үеийн харилцааны үндсэн 4 чухал баримт бичигт энэхүү 10 зарчим бүрэн дүүрэн тусгагдаж, хоёр орны харилцааны онцлогуудыг тодруулж өгсөн. Ингээд баримт бичгүүдийг тус бүрээр авч үзье.

### **1. 1991 оны Тунхаглал нь шинэ үеийн харилцааны эхлэлийн баримт бичиг болох нь**

1991 оны “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улсын найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай Тунхаглал”-ын хувьд гэвэл хоёр орны улс төрийн нөхцөл байдал харьцангуй өөр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал ижил төстэй байсан хэмээн үзэж болно. Тиймээс харьцангуй өөр нөхцөлд байсан улс төрийн байдлыг тус тусад авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна.

Энэхүү Тунхаглалыг хоёр улсын Засгийн газрын тэргүүн нар үзэглэсэн. Өөрөөр хэлбэл, хоёр улсын Гүйцэтгэх засаглалын тэргүүн нарын хэмжээнд гэсэн үг.

### **БНМАУ-ын дотоод улс төрийн нөхцөл байдал**

Тунхаглалд гарын үсэг зурсан нэг тал болох БНМАУ нь энэ үед төрийн эрх барих дээд байгууллага болох Ардын Их Хурал (нийт 430 депутаттай парламентын дээд танхим, үүнээс МАХН гишүүн 357 буюу 84%, АН гишүүн 16 буюу 3,8%, МҮДН гишүүн 6 буюу 1,4%, МСДН гишүүн 4 буюу 1%, 36 нам бусчууд, МХЗЭ гишүүн 9)<sup>1</sup>, түүнээс сонгогдсон Ерөнхийлөгч (МАХН-аас нэрийг дэвшүүлж гаргасан П.Очирбат), Улсын Бага Хурал (нийт 54 гишүүн байснаас, 4 гишүүн өөр ажилд томилогдсон тул тэдний эрхийг түдгэлзүүлж 50 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан, МАХН-31, АН-13, МҮДН-3, МСДН-3 төлөөлөлтэй байсан, байнгын ажиллагаатай, парламентын доод танхим, дарга буюу дэд ерөнхийлөгч Р.Гончигдорж-МСДН), Эвслийн засгийн газар (Засгийн газрын тэргүүн Д.Бямбасүрэн-МАХН, тэргүүн шадар сайд Д.Ганболд-МҮДН, шадар сайд Д.Дорлигжав-АН, шадар сайд Ч.Пүрэвдорж-МАХН, нийт 12 яамтай, 16 гишүүнтэй Эвслийн засгийн газар байсан)<sup>2</sup>. БНМАУ-ын Гадаад харилцааны сайдаар УБХ-аас 59,2%-ийн саналаар дэмжигдсэн Ц.Гомбосүрэн ажиллаж байлаа.

Улсын Бага Хурлын 2-р чуулганаар П.Очирбат тэргүүтэй шинэ үндсэн хууль боловсруулах ажлын комиссыг байгуулан ажилд нь оруулсан үе байлаа. БНМАУ-ын хувьд улс төрийн өөрчлөлт 1990 оны 3, 4 сараас идэвхтэй хэлэлцэгдэж мөн оны 5 сард хуралдсан АИХ-ын 9-р чуулганаар улс төрийн нэлээн олон шинэчлэлийг хийсэн. Тиймээс 1991 оны БНМАУ, ЗСБНХОУ-ын хоорондын сайн хөрш, найрамдал хамтын ажиллагааны Тунхаглал зурагдах мөчид шинэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэг ид явагдаж бүхэлдээ Монгол улсын хувьд улс төрийн тогтолцооны “шилжилтийн үе” байлаа. Өөрөөр хэлбэл, шинэ үндсэн хуулиа баталж амжаагүй, олон намын тогтолцоонд шилжсэн, эвслийн засгийн газар үйл ажиллагаа явуулж байсан ийм цаг мөчид энэ хамтын ажиллагааны тунхаглал зурагдсан билээ.

### **РСФСР-ын дотоод улс төрийн нөхцөл байдал**

Тунхаглалд гарын үсэг зурсан нөгөө тал болох РСФСР буюу ЗСБНХОУ-ын хувьд бол энэ цаг мөчид ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтсан хэвээр байсан хэдий ч Зөвлөлт Холбоот Улсад задрал явагдаад эхэлчихсэн ба тухайн үеийн удирдлагын зүгээс ямар нэг хэлбэрээр авч үлдэх арга саам эрэлхийлж байсан үе байв. ЗСБНХОУ-ын Дээд Зөвлөлийн дарга Б.Ельцин, ЗХУ-ын анхны бөгөөд эцсийн Ерөнхийлөгч М.Горбачёв нарын хооронд ЗХУ-ын “субъектуудын”



асуудлаарх тэмцэл ширүүссэн цаг мөч байсан. Өөрөөр хэлбэл, ЗХУ-ын задралын процесс нь “шинэчлэгдсэн холбооны” гэрээнээс хамаарахаар болсон үе байлаа.

Хамтын ажиллагааны Тунхаглал зурагдах мөчид буюу 2 сард Хойд хөршид маань “шинэчлэгдсэн ЗХУ”-ыг бүрэн бүтэн байлгах, ЗСБНХОУ-д ерөнхийлөгчийн албан тушаал бий болгох зэрэг асуудлуудаар бүх нийтийн санал асуулга явуулах компани ажлын бэлтгэл ид явагдаж байлаа.

### **Тунхаглалын онцлог бөгөөд чухал талууд**

1991 оны Тунхаглалаар хоёр улсын субъект хооронд хамтын ажиллагааг эхлүүлсэн. Энэ нь аймаг, муж, сум нэгдэл, үйлдвэр аж ахуйн газрын хүрээнд хэмээн тунхагласан. Тунхаглалд дамжин өнгөрөх тээврийн асуудлыг зохион байгуулах талаар анхлан тусгасан.

Түүнчлэн Тунхаглалд тусгасан чухал зүйлийн нэг нь залуу үеийнхэнд хоёр талын харилцааг ойлгуулах үүднээс залуучуудын байгууллагын хамтын ажиллагааг тал бүрээр дэмжихээ хоёр тал илэрхийлсэн ба сургуулиудын харилцааг ч өргөжүүлэхийг зүйтэй гэж үзсэн. Хоёр парламент болон сонгуульт байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхээ анхлан тунхагласан.

Уг Тунхаглалд хоёр талын Гадаад хэргийн сайд нарыг жилд нэгээс доошгүй уулзаж байхыг Тунхагласан байдаг. Хоёр улсын иргэдийн харилцан зорчих асуудлыг хөнгөвчлөх тал дээр санаачилга гаргахаа хоёр тал тунхагласан.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд гарч болох асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор хоёр талын холимог комисс байгуулан ажиллуулна хэмээн тунхагласан. Энэхүү Тунхаглал нь хоёр улсын хооронд байгуулах бусад баримт бичгийн үзэл санааны эх хэмээн заажээ.

1991 оны найрамдал хамтын ажиллагааны Тунхаглал нь ОХУ-ын хувьд Азийн улс орнуудтай байгуулсан анхны агуулга, зорилгын хувьд шинэ баримт бичиг байлаа.

Монгол улсын хувьд хойд хөршөөс ямар нэг хамааралгүйгээр үндэсний сонирхлын дагуу бие даасан бодлого явуулах “допуск-тай болсноо энэхүү баримт бичгээр баталгаажуулсан ба Оросын зүгээс ч “бид цаашид танай дотоод, гадаад асуудалд оролцохгүй” гэдгээ баталгаажууллаа. Гэхдээ талууд түүхэн харилцаагаа үнэлээд, цаашид харилцан ашигтай хамтран ажиллахаа тунхагласан явдал “далан жилийн холбоотон нэг гэр бүл” байсан хоёр улсыг “соёлтойгоор гэр бүлээ цуцлуулсан” үйл хэрэг байлаа.

**1.1993 оны Монгол, Оросын “Найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”**

1993 оны 1 сарын 20-нд Монгол улсын Ерөнхийлөгчийн ОХУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол, Орос улсын хооронд байгуулсан “Найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ”-г ОХУ-ын Дээд Зөвлөлийн 1993 оны 6 сарын 3-ны N 5100-1 тоот тогтоолоор соёрхон баталснаар хоёр улсын харилцааны баримт бичиг хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн.

1993 оны хоёр талын хамтын ажиллагааны тухайн гэрээний үндсэн ЗСБНХОУ, БНМАУ-ын хооронд 1991 оны 2 сарын 12 байгуулсан Сайн хөрш, найрамдал хамтын ажиллагааны тухай Тунхаглал хэмээн талууд Гэрээний оршилд заасан ба 1921 оны Монгол-Оросын найрамдлын гэрээг хоёр тал өндөр үнэлсэн<sup>3</sup> байлаа.

Энэ гэрээ нь ОХУ, Монгол улсын төрийн тэргүүний хэмжээнд байгуулсан анхны гэрээ байж, хоёр улсын харилцааг шинэ цаг үед явуулах баримт бичиг болсон. Хэдийгээр энэхүү гэрээ нь ОХУ-ын шинэ Үндсэн хууль батлагдаагүй зөвлөлт маягийн үндсэн хуультай байсан ч, Монголын шинэ Үндсэн хууль батлагдаад нэг жилийн нүүр үзсэн үед байгуулагдсан. Түүнчлэн хоёр улсын хоорондын Найрамдал хамтын ажиллагааны 1966 оны гэрээнээс 27 жилийн дараа байгуулсан агуулгын хувьд “асар” өөр шинжтэй гэрээ байлаа.

1993 онд Монгол-Оросын хооронд байгуулсан гэрээг уламжлалт байдлаар үзвэл хоёр орны харилцаа чанарын шинэ түвшинд гарлаа гэж үзэх үндэстэй. Үнэн хэрэгтээ гэрээ байгуулсан үеэс хойш бараг 10 шахам жилд бид энэ “шинэ түвшинг” мэдрээгүй гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, чухам энэ үед хоёр талын харилцаа зогсонги байдалтай байсан. Зогсонги гэдэг нь урьдын далайцтай үетэй харьцуулахад шүү дээ. Оросын зүгээс монгол руу, ази руу хандлагаа сулруулсан 10 орчим жил нь Монголын хувьд эерэг үр дагавартай байсан хэмээн дүгнэх боломжийг ч бас өгч байна.

1993 оны Гэрээ нь 20 жилийн хугацаанд байгуулагдсан бөгөөд цаашид 5, 5 жилээр сунгагдах боломжтой хэмээн заасан.

Ингээд гэрээ байгуулагдах үеийн Монголын улс төрийн нөхцөл байдлын талаар товч сийрүүлэе.

**Монгол улсын дотоод улс төрийн нөхцөл байдал**

1992 оны 1 сарын 13-нд Монгол улсын шинэ Үндсэн хууль батлагдлаа. Ингэснээр БНМАУ нь Монгол улс хэмээн нэрлэгдэж парламентын БНУ болсон. Төрийн эрх барих дээд байгууллага нь 76 гишүүн бүхий УИХ байх бөгөөд тэндээс олонхийн суудал бүхий улс

төрийн хүчин Засгийн газраа санаачлан байгуулахаар хуульчилсан. 1992 оны хавар анхны сонгуулийг зохион байгуулж УИХ-ыг сонгосон. Энэ сонгуульд МАХН үнэмлэхүй ялалт байгуулсан. Тэд 76 суудлын 70-ыг нь авсан бол сөрөг хүчин 5 суудалтай (МСДН - 1, МоАН, Нэгдсэн Нам, МҮДН-ын эвсэл-4)<sup>4</sup> байсан. Бие даан нэр дэвшиж сонгогдсон Гэндэнсамбуугийн Зуунай нь МАХН-ын гишүүн юм. Уг сонгууль нь томсгосон мажоритар системээр буюу, аймаг, дүүргүүдийг тус бүрийг нэг тойрог болгон, тойрог тус бүрээс 2-4 хүн сонгогдож байв. УИХ-д олонхийн суудал авсан МАХН дангаар Засгийн газраа байгуулсан. Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайдаар П.Жасрай томилогдсон. Монгол улсын шинэ үндсэн хуулийн хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн үүрэгт ажлыг П.Очирбат 1992 оны 2 сарын 12-ноос 1993 оны 6 сар хүртэл хашсан ба 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар МСДН-аас нэр дэвшин ялалт байгуулж хоёрдахь бүрэн эрх нь хэрэгжсэн.

#### **ОХУ-ын дотоод улс төрийн нөхцөл байдал**

1991 оны 12 сарын 25-нд ЗХУ оршин тогтнохоо больсон. ОХУ нь ЗХУ-ыг НҮБ-д төлөөлөх зэрэг түүний бүхий л “үүрэг, хариуцлагыг” авч үлдлээ.

1991 оны 6 сард Б.Ельцин бүх нийтийн санал хураалтаар 57%-ийн санал авч ОХУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон ба 1992 оны туршид үндсэн хуулийн зөрчил ширүүсч Орост “хоёр засаглал” тогтсон<sup>5</sup> байлаа.

1993 оны 10 сард дэд ерөнхийлөгч А.Руцкойн бүрэн эрхийг зогсоож, парламент буюу Дээд Зөвлөлөө тараасан нь хууль зүйн хувьд алдаатай байсан хэдий ч өөрчлөлт, шинэчлэлт, ардчиллыг урагшлуулах алхам байлаа хэмээн улс төр судлаачид дүгнэж байдаг. Ерөнхийлөгч Б.Ельциний энэ алхмыг Өрнөдөд дэмжсэн маягаар өнгөрөөсөн. Дээд Зөвлөлөө цэргийн хүчээр тарааж, түүний спикер Р.Хасбулатов, дэд ерөнхийлөгч А.Руцкой нарын талынхныг “Лефортов”-т суулгахад армийн дээд удирдлагын дор хаяад 2/3 нь Б.Ельциний талд байсан явдал нөлөөлсөн.

1993 оны 12 сарын 12-нд батлагдсан ОХУ-ын шинэ үндсэн хуульд Ерөнхийлөгчийн засаглалтай, хоёр танхим бүхий парламенттай, холбооны БНУ хэмээн тунхагласан. Уг үндсэн хуулиар түүнд засвар оруулах, зарим зүйлийг эргэн харах тухай саналыг Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, Төрийн Дум, Засгийн газар, ОХУ-ын субъектуудын хууль тогтоох байгууллагууд, түүнчлэн Холбооны Зөвлөл, Төрийн Думын депутатуудын 1/5 –ээс багагүй тоотой депутатын бүлэг санал оруулах эрхтэй болсон.



### 1993 оны Гэрээний агуулгыг нягталбал

Энэхүү гэрээ нь аливаа нэг үзэл суртлаас ангид байж бие биеийн хүсэл эрмэлзлийг хүндэтгэн үзэх агуулга бүхий Монгол, Оросын хоорондын анхны гэрээ байсан. Уг хорин зүйл бүхий гэрээний 1, 2-р зүйлд нийтлэг харилцааны асуудал тусгагдсан ба 4, 5, 6, 7-р зүйлд улс төрийн болон олон улсын улс төрийн харилцааны талаар тунхагласан. Гэрээний 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15-р зүйлүүдэд хоёр орны хоорондын харилцааны бүхий л салбарын асуудлыг багтаажээ. Шинэ гэрээний шинэлэг нэг зүйл бол 3-р заалт буюу хоёр орны парламент болон сонгуульт байгууллагуудын хамтын ажиллагааг эхлүүлэн хөгжүүлэхийг тусгасан явдал. Гэрээнд түгээмэл асуудлаас гадна шинэ нөхцөл байдалд зохицуулан тусгасан хэд хэдэн заалтууд байгаа билээ. Тухайлбал, дор дурдсан зүйлүүдийг цаашдын гэрээ, хэлэлцээр анхаарч халгалж явах чухал тул тусгайлан энд өгүүлж байна.

1993 оны гэрээнд хоёр тал бие биений эсрэг чиглэсэн цэрэг-улс төрийн эвсэлд үл нэгдэх, ийм утгатай аливаа гэрээ хэлэлцээрийг гуравдагч улстай байгуулахгүй байх талаар тохирсон. Түүнчлэн гэрээ нь анх удаа хоёр орны хоорондын холбоотны асуудлыг үгүй хийсэн.

Гэрээгээр Монгол улсыг Ази Номхон далайн бүс нутгийн улс хэмээн ОХУ зөвшөөрөн энэ бүс нутаг хоёр болон олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг чухалчилсан байдаг. Гэрээнд “аль нэг талын аюулгүй байдлын асуудалд заналхийлж болзошгүй гэж үзвэл харилцан зөвлөлдөнө”<sup>6</sup> хэмээн тусгажээ.

Гурван талын хөрөнгө оруулалт бүхий хамтын ажиллагааг дэмжихээ энд дахин нотолсон байна.

ОХУ-ын шинжлэх ухааны салбартай, нэн ялангуяа суурь судалгаан дээр хамтран ажиллах талаарх нөхцлийг бүрдүүлнэ хэмээн заасан байгааг Монголын тал бүрэн дүүрэн ашиглах ёстой.

Хоёр улсын хоорондын гэрээнд гарын үсэг зурсан анхны Ерөнхийлөгчдийн хувьд ижил төстэй зүйлүүд олон бий. Тухайлбал, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат нь МАХН-аас Ерөнхийлөгчийн суудалд суусан ба ЗСБНХОУ-ын Дээд Зөвлөлийн дарга Б.Ельцин нь тухайн үедээ ЗХУКН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, Москва хотын Намын хорооны дарга ч байсан. Энэ албан тушаалаасаа хоёулаа Ерөнхийлөгчид дэвшсэн төдийгүй хоёул өөрчлөлт, шинэчлэл, ардчиллыг дэмжиж ажилласан шилжилтийн үеийн төрийн тэргүүнүүд байлаа. Хоёул 1990 оны хавар 5 сард АИХ, ДЗ-ийн даргад дэвшин ажиллаж байгаад Ерөнхийлөгчид нэр дэвшин сонгогдсон төрийн ажлын ихээхэн туршлагатай хүмүүс байсан.

### **3. Улаанбаатарын Тунхаглал**

Улаанбаатарын тунхаглал нь 1993 оны найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд талууд үнэнч байгаа гэдгээ батлан харуулсан төдийгүй цаашид талуудын хамтран ажиллах чиглэлүүдийг улам тодруулсан баримт бичиг байлаа.

Улаанбаатарын тунхаглалыг гаргаснаар Монгол улс, Оросын Холбооны улсын хоорондын харилцаанд чухал үйл явдал болсон гэдэгт талууд итгэлтэй байгаа. Хойд хөршийн төрийн тэргүүн Монгол улсын Ерөнхийлөгчийн урилгаар 2000 оны 11 сарын 13-14-нд Улаанбаатар хотноо 27 жилийн дараа Монгол улсад дээд хэмжээний айлчлал хийсэн төдийгүй энэ айлчлалаар хоёр орны харилцааны асуудлыг тодруулсан “Улаанбаатарын тунхаглал” гаргасан нь айлчлалыг агуулгын хувьд улам баяжуулсан төдийгүй хоёр орны харилцааг “харьцангуй зогсонги” байдлаас гаргасан үйл явдал болсон.

Оросын хувьд хэт Өрнөд рүү чиглэсэн бодлогоос Өрнө, Дорны бодлогоо тэнцвэржүүлэх чиг барьж эхэлсэн бодлогын хүрээнд Монгол улсыг Дорно зүгт гарах “гүүр”, өргөн удам нутгаар хил залгаа байгаа хөрш, эртний сайн харилцаатай улс гэдэг талаас нь харж “Улаанбаатарын Тунхаглал” гарсан.

Энэ тунхаглал хоёр улсын харилцаанд гарсан улс төрийн анхны баримт бичиг тул давуу болон учир дутагдалтай талууд байсныг судлаачийн хувьд хэлж байгаа.

Ингээд Улаанбаатарын тунхаглал гарах энэ цаг үед хоёр орны дотоод улс төр, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал хэр байсныг товчлон харьцуулж үзэх нь зүйтэй.

#### **Монгол улсын дотоод улс төрийн нөхцөлд байдал 2000 онд**

Монгол улсын хувьд улс төрийн тогтолцоо нь 1993 оны Гэрээний үеийнхтэй адил байж 2000 оны УИХ-ын сонгуулийн дүнгээр байгуулагдсан парламент, засгийн газар нь үйл ажиллагаагаа явуулж байсан цаг үе байсан. 1997 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшин ялалт байгуулсан Ерөнхийлөгч Н.Багабандийн бүрэн эрх хэрэгжээд 3 жил гаруй болж байсан ба 2000 оны парламентын сонгуулиар МАХН 72 суудал авч үнэмлэхүй олонхи болж, МҮАН, Монголын Шашинтны Ардчилсан Намын “Ардчилсан Холбоо” эвсэл, ИЗН, Ногоон Намын “Иргэний Зориг-Ногоон Нам” эвсэл, Эх Орон- МАШСН тус бүр 1 суудал авч, бие даагч 1 хүн сонгогджээ<sup>7</sup>. Олонхийн суудал авсан МАХН-ын дарга Н.Энхбаяр засгийн газраа эмхлэн байгуулаад 5 сар шахам болж байлаа. Эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байсныг дараах статистик харуулж



байна. 2000 оны байдлаар, ДНБ-ий өсөлт дөнгөж 1,1 хувьтай, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 426,2 ам доллар, инфляци 8,1 хувь, малын тоо толгой 30,2 сая, гадаад худалдааны алдагдал 78,7 сая ам доллар, ам долларын ханш 1076,4 төгрөг, ДНБ-ий хэмжээ оны дүнгээр 1044 тэрбум төгрөг, гадаад валютын нөөц 160 сая ам доллар, төсвийн алдагдал -6,4 хувьтай байж ерөнхийдөө эдийн засгийн үзүүлэлтүүд сайнгүй<sup>8</sup> байсан.

### **ОХУ-ын дотоод улс төрийн нөхцөл байдал 2000 онд**

1999 оны 12 сард ерөнхийлөгч Б.Ельцин ажлаа Ерөнхий сайд В.Путинд шилжүүлэн өгч өөрийн “залгамжлагчаар” тодруулсан. Харин 2000 оны 3 сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд В.Путин ялалт байгуулж 5 сард тангаргаа өргөн ажилдаа орсон. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгч Путин ажлаа аваад хагас жилийн дараа Монголд төрийн айлчлал хийжээ.

2000 он бол 1993 оны хоёр талын гэрээ байгуулах үеийг бодвол ОХУ-ын улс төрийн тогтолцоо тогтворжсон, эдийн засгийн нөхцөл харьцангуй сайжирч эхэлсэн цаг үе байлаа.

1999-2003 оны Төрийн Думд зүүний хүчин нийт суудлын 24 илүү хувьтай байсан ч төвийн хүчин болох “Единство”, түүнийг дэмжсэн баруун төвийнхний нөлөө хүчтэй байснаас энэ үед ерөнхийлөгчийн бодлого тууштай хэрэгжих таатай нөхцөл бүрдсэн.

ОХУ-ын Төрийн Думын 1999 оны холимог системээр явагдсан сонгуулийн дүнгээр ОХУК-аас 90 мандат, АПДГ-аас 39 мандат, Единство 82 мандат, Народный депутат бүлэг 59 мандат, ОВР 45 мандат, Регион России 41 мандат, СПС 32 мандат, Яблоко 21 мандат, ЛДПР 17 мандатыг тус тус авч Оросын парламентын доод танхим буюу хууль тогтоох дээд байгууллага байгуулагдсан байлаа.

ОХУ-ын эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүд гэвэл дараах байдалтай байлаа. Үүнд: Гадаад өр 178,2 тэрбум ам доллар, валютын нөөц 19,8 тэрбум ам доллар, ДНБ 2003 оны үнээр 11217,3 тэрбум рубль, түүхий нефтийн экспорт 25,2719 тэрбум ам доллар, байгалийн хийн экспорт 16,6441 тэрбум ам доллар, 25 тэрбум ам долларын хөрөнгө зөвхөн 2000 онд гадагшаа гарсан<sup>9</sup> байлаа.

### **Тунхаглалын агуулгыг сийрүүлбэл**

Ингээд Улаанбаатарын Тунхаглалыг дараах 4 зүйлээр агуулга талаас нь авч үзлээ. “Улаанбаатарын тунхаглал”-ын 25 зүйлийн 6 пункт нь эдийн засгийн агуулгатай байсан нь хоёр улсын харилцаанд ноёрхож байсан геостратегийн хуучин хандлага эдийн засгийн сонирхол давамгайлсан шинэ харилцаанд шилжиж буйг батлан

харуулсан хэрэг байлаа. Энэ тунхаглал нь Монгол улсын хувьд чухал ач холбогдолтой хэдий ч тийм “чухал тунхаглал”-д тусгагдсан зарим эдийн засгийн асуудлыг зөвхөн хоёр аж ахуйн нэгжийн хооронд харилцан шийдэж болохоор байсныг судлаачийн хувьд миний бие “Улаанбаатарын тунхаглал түүний хувь заяа”<sup>10</sup> өгүүлэлдээ 2002 онд тэмдэглэсэн.

#### **Улаанбаатарын тунхаглалын шүүмжлэлтэй талууд**

ОХУ-ын бүс нутгийн байгууллага болох «Сибирское соглашение» -д ач холбогдол өгч хамтын ажиллагааг өргөжүүлэхийг баримт бичигт тунхагласан хэдий ч энэ үйл ажиллагаа амжилт олоогүй буюу зохих үр дүнгээ өгсөнгүй.

Тунхаглалын 4-р зүйлд хоёр орны хоорондын төмөр замын хөнгөлөлттэй тариф, гаалийн татвар хураамж, худалдааг либералчлах, өргөжүүлэх талаар тусгасан нь одоо хэр оновчтой шийдэгдээгүй бөгөөд ахиц дэвшил муутай байгаа. Энэ асуудал нь бараг хоорондоо худалдаа хийхгүй буюу худалдааны тэнцэл сөрөг дүнтэй хоёр улсын хооронд худалдааг либералчлах гэдэг нь зүгээр нэг хоосон зүйлтэй зууралдахтай агаар нэг зүйл болсон.

Монгол, Орос, Хятадын гурван талын хүрээнд ачаа тээврийн асуудлыг боловсронгуй болгох ажлын талаар шинжээчдийн багийг үргэлжлүүлэн ажиллуулна хэмээн тохирсон ч ажлын үр гарсангүй ажил нь бараг зогссон. Гурван улсын дамжин өнгөрөх тээвэр нь зөвхөн төмөр замаар хязгаарлагдаж байгаа тул асуудлыг Хятадын төмөр зам, УБЖД хоорондоо яриад шийдэхээр боломжтой тул Тунхаглах зайлшгүй шаардлага алга байлаа. Улаанбаатарын тунхаглалд нэлээн хэдэн зүйлийг зөвхөн аж ахуйн нэгж, ведомства хоорондын хэмжээнд зохицуулахаар зүйлүүд байсан тухайлбал, 7, 8, 9, 10-р пункт бүхэлдээ тийм байсан.

Тунхаглалын 15, 16-р зүйлд НҮБ-ын хүрээнд хамтран ажиллах, үйл түүний ажиллагааг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, Мянганы хөгжлийн тунхагийн хүрээнд хамтран ажиллах гэх зэргээр хэвшмэл үг хэллэгээр асуудлыг томъёолсон байгаа нь хоёр орны харилцаанд байгаа буюу гарч болох асуудалд түлхүү анхаархыг орхигдуулсан зүйл болжээ. Ер нь ОХУ нь Монголын талаарх гомдлоо НҮБ-д өргөн бариад явахгүй нь нийтэд ойлгомжтой зүйл. Харин Монголын хувьд байж болох ч олон улсын хүчний харьцаанд өөрчлөлт гарсан өнөө үед НҮБ-ын үүрэг роль нэн шаардлагатай бус бөлгөө.

#### **Улаанбаатарын тунхаглалын ач холбогдол бүхий талууд**

Улаанбаатарын тунхаглал нь өнгөрсөн түүхэн харилцааг

хүндэтгэн, шинэ харилцааг баталгаажуулсан 1993 оны найрамдлын гэрээг бүхэлд нь сайшаасан баримт бичиг байлаа.

Улаанбаатарын тунхаглал нь ОХУ нь Монголтой зогсонги байсан харилцаагаа идэвхжүүлэх анхны алхам болсноороо ач холбогдолтой.

Тунхаглалд УБЖД-г сонирхсон талууд Европ-Азийг холбосон тээврийн хэмжээнд ашиглахыг урьсан нь Монгол, Орост аль алинд нь хэрэгтэй зүйл болсон.

Хоёр тал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хүрээнд хамтран ажиллаж харилцаа холбоог улам өргөжүүлэхийг дэмжсэн явдал чухал зүйл байлаа. ОХУ нь дэлхийн улс төрийн нөлөө бүхий улс, цэрэг зэвсгийн боломж, техникийн хангамж, Монгол улсын аюулгүй байдлыг сахин хамгаалахад дэмжлэг үзүүлэх улсын хамтран ажиллах, хуучин хамтын ажиллагааг сэргээх чиглэлийг энд тунхагласан нь ач холбогдолтой болсон.

Тунхаглалын 13, 14-р зүйлд хоёр улсын хилийн асуудлыг онцгойлон тусгасан нь мөн чухал байлаа. Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг цөмийн зэвсэг бүхий таван улсын хамтарсан мэдэгдэлд гаргасан баталгаандаа ОХУ хэвээр гэдгээ дахин нотолсон<sup>11</sup> байна. Түүнд нь Монгол улс гүн талархалтай байгаагаа ч илэрхийлсэн.

ОХУ нь терроризм, хар тамхи, сепаратизм зэрэг асуудалтай тул Монгол улсыг энэ тал дээр бааз болгох аюул байгаа тиймээс энэ асуудлыг хөндсөн Тунхаглалын 24-р зүйл нь ач холбогдолтой зүйл.

#### **Тунхаглалын үүргээ гүйцэтгэсэн пунктууд**

Энэ тунхаглал нь Монгол-Оросын хооронд үүссэн Зөвлөлтийн Их өрийн асуудлыг зохистой шийдэхэд том алхам болсон бичиг баримт гэж үзэж болно.

Тунхаглалын 23-р зүйлд Монголын тал ШХАБ-ын зарим үйл ажиллагаанд сонирхлоо илэрхийлэн ямар хэлбэрээр оролцож болохоо мэдэгдсэн. Энэ үүргийн хүрээнд Монгол улс 2001 оноос ШХАБ-ын ажиглагчийн статустай болсон. Тиймээс энэ пункт биелсэн гэж үзэж болно.

#### **Тунхаглалын үүргээ гүйцэтгээгүй пунктууд**

Тунхаглалын 5-р зүйлд дурдсан Зүүн Хойд Азид хэрэгжүүлж болох эрчим хүчний томоохон төслүүдэд хамтран ажиллах тал дээр хоёр талууд ач холбогдол өгсөн байдаг. Энэ нь нэгдүгээрт тухайн бүс нутгийн талаар дэлхий нийт хүлээн зөвшөөрсөн зүйл үгүй, хоёрдугаарт гэвэл эрчим хүчний төслүүд нь Монголд ямар нэг хамааралгүйгээр хэрэгжээд эхэлсэн. Тухайн үед ОХУ нь Зүүн Азийн эрчим хүчний



төсөлд Монгол улс эдийн засаг, газарзүйн байрлалын хүчин зүйлээрээ оролцохыг дэмжиж энэхүү Тунхаглалд оруулсан байлаа.

Зургадугаар пункт нь бүхэлдээ 2009, 2010 он хүртэл бүхэлдээ хэрэгжээгүй бөгөөд Москва, 2009 оны дээд хэмжээний уулзалтын дараагаар зарим нэг зүйл нь хөдөлгөөнд орсон.

#### **Тунхаглалын нийтэд ойлгомжгүй пунктууд**

Тунхаглалын 17-р зүйлд даяаршлын асуудалд талууд анхаарангаа, түүнээс үүдэн гарч буй улс орнуудын хоорондын хөгжлийн ялгааг шинэ аюул хэмээн үзсэн. 18-р зүйлд Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх Гэрээ, Цөмийн туршилтыг бүх нийтээр хориглох Гэрээ, Химийн зэвсгийг хориглох Конвенцид бүх улс орон нэгдэн орно гэдэгт талууд найдаж байгаагаа илэрхийлсэн нь Тунхаглалын энэ зүйлийг тун ч ойлгомжгүй байдалд оруулсан гэж дүгнэж болох юм.

Стратегийн давшилтын гэрээ-2 бүрэн утгаараа хүчин төгөлдөр болж хэрэгжих, Стратегийн давшилтын гэрээ -3 –г байгуулах нь цаашид цөмийн зэвсэглэлийг хорогдуулах үндэс суурь хэмээн томъёолсон нь өнөөгийн үнэнд ойлгомжгүй зүйлийн нэг болсон.

Зүүн Хойд Ази хэмээн улс төрийн хэллэгт хэвшмэл болж чадаагүй бүс нутгийн нэр томъёог хэрэглэхийн зэрэгцээ тэнд бүх сувгаар яриа хэлэлцээрийн арга механизмыг идэвхижүүлэхэд талууд онцгой анхаарсан нь эргэлзээ төрүүлэхүйц зүйл болсон.

Солонгосын хойгийн асуудал бол Монгол,Орос хоёрт улс төрийн чухал ач холбогдол бүхий зүйл тиймээс энэ талууд байр сууриа илэрхийлсэн нь сайн хэрэг. Гэхдээ энэ асуудлаар Талуудын байр суурьтай ялгаатай тул нэг Декларацид ингэж ойлгомжгүй хэлбэрээр томъёолох нь буруу зүйл.

#### **4. Москвагийн Тунхаглал<sup>12</sup>**

Монгол улсын Ерөнхийлөгчийн ОХУ-д хийсэн төрийн дээд хэмжээний айлчлалын үеэр буюу 2006 оны 12 сарын 8-нд Москва хотноо Монгол улс, ОХУ хамтарсан Москвагийн Тунхаглал гаргасан билээ. 2000 оны Улаанбаатарын Тунхаглалд тодорхой үнэлэлт дүгнэлт өгч, олон улсын болон хоёр талын хооронд бий болсон зарчмын асуудлыг шийдэхэд түлхэц өгөх үүднээс талууд илүү нээлттэй, бүрэн итгэлцлийн түвшинд энэхүү Тунхаглалыг гаргасан.

Энэхүү Тунхаглал нь 1993 оны Гэрээ, 2000 оны Улаанбаатарын Тунхаглал гарах үеийн хоёр орны улс төр, нийгэм эдийн засгийн байдал харьцангуй тогтворжсон, зарим талаараа сайжирсан цаг үед болсноороо онцлог юм.

### **Монгол улсын улс төрийн дотоод нөхцөл байдал**

Монгол улсын төр, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал хууль эрхзүйн хувьд хэвийн буюу 2000 оны УБ-ын Тунхаглалын үеийнхтэй адил төстэй байсан хэдий ч 2004 оны парламентын сонгуульд МАХН 36, Ардчилсан Нам, Эх Орон Намын “Эх орон-Ардчилал” эвсэл 36, БНН 1 суудал авч, Ардчилсан Намын 3 гишүүн бие даан нэр дэвшиж сонгогдож 2006 он гэхэд 2 Засгийн газрын байгуулсан үе<sup>13</sup> байлаа. Ерөнхий сайд Ц.Элбэгдоржийн Эвслийн засгийн газар огцорч ерөнхий сайд М.Энхболдын Үндэсний эв нэгдлийн засгийн газар байгуулагдсан үе байсан. 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшсэн Н.Энхбаяр бүрэн эрхээ хэрэгжүүлээд 1 жил болж байлаа. Нийгэм эдийн засгийн гол үзүүлэлтүүд дараахи түвшинд байлаа. 2006 оны байдлаар, ДНБ-ий өсөлт дөнгөж 8,6 хувьтай, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 998 ам доллар, инфляци 6,2 хувь, малын тоо толгой 34,8 сая, гадаад худалдаа 107 сая ам долларын ашигтай, ам долларын ханш 1165 төгрөг, ДНБ-ий хэмжээ оны дүнгээр 1044 тэрбум төгрөг, гадаад валютын нөөц 687,25 сая ам доллар, улсын төсөв 3,1 хувийн ашигтай гарсан ерөнхийдөө эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч<sup>14</sup> байсан.

### **ОХУ-ын улс төрийн дотоод нөхцөл байдал**

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины 2 дахь бүрэн эрхийн хугацаа хэрэгжээд 2 жил гаруй болж байсан ба Оросын 2003 оны Төрийн Думын сонгуульд улс төрийн 4 хүчин дараахи тооны мандаттай болжээ. Үүнд: Единая Россия- 223 мандат (120/103), КПРФ- 52 (40/12), Родина – 37 (29/8), ЛДПР – 36 (36/0), НПРФ – 17 (0/17).

Ерөнхийлөгчийн засаглалыг хүчтэй болгох үүднээс улс төрийн томоохон өөрчлөлт явуулсан нь улсын хэмжээний болон субъектуудын улс төрийн үйл явцыг үндсээр өөрчилсөн. Үүнд: субъектуудын хууль тогтоох байгууллагуудын депутатуудын 50-аас доошгүй хувийг сонгуулийн пропорциональ системээр зайлшгүй явуулах заалт, Холбооны Зөвлөл буюу Оросын парламентын дээд танхимыг бүрдүүлэх журамд өөрчлөлт оруулж, тэндээс субъектуудын амбан захирагч, хурлын дарга нарыг гаргасан, субъектуудад сонгуулийн өмнөх эвсэл, улс төрийн намууд байхыг хориглосон, амбан захирагч нарыг сонгуулиар бус дээрээс томилдог болгосон, намын нэрээр сонгогдох босгыг алгуур өндөрсгөв.

Барууны болон баруун төвийн чиглэлтэй улс төрийн хүчнүүдийн байр суурь суларч, центрист, зүүн болон зүүн төвийн улс төрийн хүчнүүдийн байр суурийн бэхжилт хүчтэй ерөнхийлөгчийн

засаглалыг улам бэхжүүлсэн. 2001 онд батлагдаж, 2006 онд шинэчлэгдсэн “Улс төрийн намуудын тухай” хуулиар тэдгээрийг “цэгцлэх” бодлогыг явуулж байна. Улс төрийн намуудын хэмжээнд ОКН, ЛАН хоёр л төлөвшөөд байгаа.

2006 оны байдлаар ОХУ-ын эдийн засгийн нөхцөл байдлыг тоймолбол.

Гадаад өр 257,2 тэрбум ам доллар, валютын нөөц 237,5 тэрбум ам доллар, ДНБ 2003 оны үнээр 16286,5? тэрбум ам.доллар, түүхий нефтийн экспорт 102,2829 тэрбум ам доллар, байгалийн хийн экспорт 43,8062 тэрбум ам доллар, зөвхөн 2006 онд гэхэд гаднаас 41,6 тэрбум ам долларын хөрөнгө орж ирсэн<sup>15</sup> байлаа.

### **Тунхаглалын ач холбогдол бүхий пунктууд**

1993 оны Гэрээндээ талууд үнэнчээ дахин нотолсон. 2003 онд Монгол, Оросын хоорондын шилжих рублийн өрийн асуудлыг зохицуулсан явдлыг цаашид хоёр орны хоорондын харилцааг бүх талаар өргөжүүлэх шинэ боломжийг бий болголоо хэмээн талууд сэтгэл хангалуун тэмдэглэсэн.

Талууд эдийн засгийн олон салбарт тухайлбал, түлш эрчим хүч, геологи уул уурхай, тээвэр, хөдөө аж ахуй, банк санхүүгийн салбарууд, түүнчлэн олон улсын стандарт, эдийн засгийн бодит нөхцөлд нийцсэн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал гэдэгт санал нийлсэн байна.

АПЕК-д Монгол улсыг элсэхэд ОХУ дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн явдал манайд чухал зүйл болно.

### **Тунхаглалын шүүмжлэлтэй пунктууд**

Энэ баримт бичигт дээд хэмжээний айлчлалын явцад хоёр талаас гарын үсэг зурсан 8 санамж бичиг, гэрээний тухай ердийн протоколын шинжтэй зүйлийг нэг бүрчлэн бичсэн явдал байлаа.

Харилцан хөрөнгө оруулалт, худалдааг өргөжүүлэх, таатай орчинг бүрдүүлэх тал дээр хуулийн хүрээнд талууд хамтран хүчин чармайлт гаргах ёстой гэдэг дээр нэгдмэл байлаа хэмээн тунхагласан явдал бол хууль нь ийм байдлыг бий болгоход төвөгтэй хэлбэрээр батлагдсан тул асуудал дагуулсан зүйл юм.

Монгол-Оросын засгийн газар хоорондын комисс нь үйл ажиллагааны хувьд тогтмолжсон хэдий ч хоёр орны хамтын ажиллагааг системтэй төлөвлөгөөтэй тууштай урагшлуулах тал дээр дорвитой ажил хийхгүй байгааг талууд сайн ажил хийж байгаа хэмээн дүгнэж байгаа нь учир дутагдалтай зүйл.

Хоёр талын хамтарсан үйлдвэр аж ахуйн газруудын техникийн шинэчлэл, удирдлагыг чадваржуулах, хөрөнгө оруулалтын төслийг



хэрэгжүүлэх замаар хүчин чадлыг нэмэгдүүлэхэд сонирхолтой байгаагаа талууд баталсан хэмээн тунхаглахаас илүү тэдгээр аж ахуйн нэгжүүдийг бизнесийн горимд шилжүүлэх тал дээр анхаарах чухал байлаа.

УБЖД асуудлаар талууд өргөжүүлэх, хөгжүүлэх, шинэчлэх нь чухал гэдгийг тэмдэглэсэн ба түүний суурь гэрээг шинэчлэнэ гэж тодруулсан байдаг. УБЖД хувьд 1949 оны гэрээг шинэчлэхээс асуудал эхлэх ёстой гэдгийг талууд шууд хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь учир дутагдалтай зүйл.

Иргэдийн харилцан зорчих асуудлыг хөнгөвчлөх талаар талууд санал нэгдсэн хэдий ч энэ асуудал олон жилээр шийдэгдээгүй байна. Хөвсгөл, Байгал нуур дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх асуудлыг аж ахуйн нэгж хоорондын хэмжээнд шийдэх асуудал билээ.

### **Тунхаглалын үүргээ гүйцэтгэсэн пунктууд**

Хоёр тал боловсрол, соёл, аялал жуулчлал, хүмүүнлэгийн салбар дахь хамтын ажиллагааг улам идэвхжүүлэх, агуулгыг сайжруулах талаар санаачилга гаргаж энэ тунхаглалд илүү тод томруун тусгасан явдал Москвагийн Тунхаглалын агуулгыг баяжуулсан явдал болжээ.

Талууд ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний талаар Тунхаглалд тусгасан нь өнөөгийн ажилгүйдлийн нөхцөлд зөв зүйтэй асуудал болсон.

Батлан хамгаалах болон хүчний байгууллагын болон Аюулгүй байдлын хамтын ажиллагааг илүү оновчтой, харилцан ач холбогдолтой болгох талаар талууд санаачилга гаргасан зүйл нь үүргээ сайн гүйцэтгэж буй зүйл хэмээн үзэх үндэстэй.

Бүс нутгийн болон олон улсын асуудлаар ОХУ-тай адил төстэй байр суурьтай гэдгээ Монгол улс тунхагласан нь чухал зүйл. Хоёр улс тогтвортой хөгжлийг хангах үүднээс өөр хоорондоо болон сонирхсон талуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бэлэн гэдгээ Тунхагласан нь чухал ач холбогдолтой зүйл билээ.

Дэлхий дахины соёл иргэншлийн олон хэлбэрийг хүндэтгэн үзэж улс бүрийн хөгжлийн бие даасан тусгаар сонголтыг талууд хүлээн зөвшөөрсөн нь ач холбогдолтой зүйл. Олон улсын аливаа хямралыг шийдэхэд оролцогч талуудын хууль ёсны сонирхлын дагуу олон улсын эрхзүйн хэм хэмжээнд улс төр-дипломатын аргаар зохицуулахыг талууд тэргүүн зэрэгт тавьсан нь зүйтэй.

Монгол улсын аюулгүй байдлын баталгааг гаргасан цөмийн зэвсэг бүхий таван улсын хамтарсан мэдэгдлийг ОХУ сахин хангана гэдэгтээ үнэнчээ дахин нотолсон явдал чухал зүйл байлаа.

**Тунхаглалын үүргээ гүйцэтгээгүй буюу орхигдсон пунктууд**

Тунхаглалд ШХАБ-ын талаарх хоёр талын байр суурийг илүү оновчтой, ойлгомжтой хэлбэрээр тусгах нь ажиглагчийн хүрээнд Монгол улс ШХАБ-ын хоорондын цаашдын хамтын ажиллагааг ойлгомжтой болгох байлаа. ШХАБ-ын хүрээнд хамтын ажиллагааны тэргүүлэх салбар дахь хамтын ажиллагааг нээлттэй, харилцан ашигтай хэлбэрт шилжүүлэн гишүүд, ажиглагчийн оролцооны хувь хэмжээг тодорхой бус байгаа өнөө үед үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар талууд тусгасан нь энэ Тунхаглалын хувьд үүргээ гүйцэтгээгүй зүйл болноо.

Евразийн эдийн засгийн хамтын нийгэмлэгт Монгол улс элсэх боломжийн талаар судалж байгаа гэдгээ Монголын тал мэдээлсэн явдал нь “асуудал” дагуулсан зүйл болсон байна.

**Тунхаглалын нийтэд ойлгомжгүй пунктууд**

Монгол-Оросын хоорондын гадаад худалдааны алдагдал 1 тэрбум ам доллар гараад байхад талууд цаашид худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх тал дээр харилцан хүчин чармайлт гаргана хэмээн заасан нь тун ойлгомжгүй зүйл. Улаанбаатарын Тунхаглалд тусгасан нэг алдаа буюу Зүүн Хойд Азийн бүс нутаг гэсэн нэр томъёог дахин ашиглан тэнд хамтын ажиллагааг өргөжүүлнэ хэмээн тунхагласан нь ойлгомжгүй байдалд оруулж байна.

**ДҮГНЭЛТ**

Монгол, Оросын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны гэрээ нь хоёр орны харилцааг шилжилтийн үед төдийгүй зах зээлийн харилцааны өнөөгийн нөхцөлд, олон улсын харилцааны шинэ үе орчинд зохицуулж буй баримт бичиг.

1991 оны Хамтын ажиллагааны Тунхаглалд оролцсон ЗСБНХОУ нь 8 сарын дараа ОХУ хэмээн нэрлэгдэх болсон бол БНМАУ нь нэг жилийн дараа Монгол улс хэмээн нэрлэгдэв. Хэдийгээр гэрээнд оролцсон субъектуудын улс төр, нийгэм, эдийн засгийн бодлогын хувьд эрс өөрчлөгдсөн ч гадаад харилцааны залгамж чанар хадгалагдан үлдэж хоёр хөршийн хооронд байгуулсан Тунхаглалд өөрчлөлт ороогүй болно.

1990-ээд оны эхээр Орост ард иргэдийн дунд “не мы содержим государство, а оно нас обязано кормить, финансировать и одевать” гэсэн ойлголт хүчтэй байсан бол Монголд “төр улсаа харахаа больёо, өөрсдөө аргаа бодохоос гэсэн ойлголттойгоор

хүн гадаад паспорт өвөртлөн ганзагын наймаанд мордсон". Харин нэлээн хожуу Монголчуудын дунд "төр бүхнийг хийх ёстой гэсэн тэжээвэр санаа газар авсан" нь оросуудын 1990 оны эхээр баримталж байсан ойлголттой ойролцоо болж эхэлсэн.

Олон улсын улс төр, эдийн засгийн нөхцөл эрс өөрчлөгдөж хүчний харьцаа өөрчлөгдсөн цаг үед урьдын ижил ашиг сонирхол үгүй болсон, өөрсдийн эрх ашгаа өөрсдөө тодорхойлсон, улс төрийн ондоо тогтолцоо, эдийн засгийн өөр хүч чадалтай, нийгэм эдийн засгийн шийдвэрлэх асуудлын далайцаар эрс өөр, соёл, амьжиргааны ахуй өөр, газарзүйн байрлалын хувьд мөнхийн хөрш, өмнөх системд улс төр, үзэл суртал, нийгэм эдийн засгийн хувьд хамгийн ойр дотно холбоотон байсан зэрэг хоёр орны хамтын ажиллагааг баталгаажуулсан баримт бичиг юм.

1991 оны гэрээ байгуулах үед болон 1993 оны Гэрээг байгуулах үеийн олон улсын нөхцөл байдлын талаар судлан тогтоох нь Гэрээний бодит байдалд чухал зүйл. Иймээс 1991 оны 2 сард байгуулсан сайн хөршийн тунхаглалд олон улсын байдал хэр нөлөөлсөн талаар дурдах нь зүйтэй. Олон улсын хэмжээнд сөргөлдөгч талууд үгүй болж, эвсэл болон тэмцэлдэгчид ерөнхийдөө нэгэн том эвсэлд түр зуур ч гэсэн хамаарах болсон.

1991 оны Тунхаглал, 1993 оны Гэрээнд 1921 оны найрамдал хамтын ажиллагааны гэрээг хоёр орны хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээн тэмдэглэсэн байна.

1991, 1993 оны Тунхаглал, гэрээнд хоёр тал эдийн засгийн нээлттэй бодлогыг харилцан дэмжих, харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, түүнд таарсан нөхцлийг бүрдүүлэх үүрэг хүлээсэн ба хамтарсан үйлдвэр аж ахуйн газар байгуулж, түүнд гуравдагч улсаас түнш оролцохыг хөхиүлэн дэмжинэ хэмээн тунхаглан баталгаажуулсан.

1991 оны Тунхаглалд БНМАУ-ыг Төв Ази, Ази Номхон далайн бүсэд хамруулан үзэж байсан бол 1993 онд Монгол улсыг Ази Номхон далайн бүсэд хамруулах болсон.

1990-91 онууд Монголд намын хүчин зүйл хүчтэй болж, Орост лидер удирдагчийн хүчин зүйл хүчтэй болсон цаг мөч байлаа.

Монгол угсааны олон улс ОХУ-д аж төрдөг тул монголын язгуур эрх ашиг бол ОХУ-тай бүх талаар ойртон хамтран ажиллах нь чухал.

Гадаад улс орнуудтай гэрээ, хэлэлцээрийг хийхдээ тухайн гэрээг байгуулж буй субъектууд хэр эрхзүйн чадамжтай эсэх, улс оронд хэрэгжиж буй хууль эрхзүйн актуудтай нийцэж буй эсэх,



ерөнхийдөө талуудын сонирхлыг бүрэн илэрхийлж байгаа эсэх зэрэг бичигдсэн болон “бичигдээгүй” хуулиудыг хэр авч үзсэн зэрэг олон асуудлыг цаашид анхаарч байх үүднээс энэхүү судалгааны өгүүлэл бичигдсэн болно.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин 2000 онд Монголд хийсэн айлчлалын үеэр “Орос-Монголын харилцааг урьдах түвшинд сэргээх нь бидний гол зорилт”<sup>16</sup> хэмээн тодорхойлсон.

Улаанбаатар, Москвагийн Тунхаглал нь ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины 2 бүрэн эрхийн хугацаанд хийгдсэн баримт бичиг. ОХУ нь Ерөнхийлөгчийн хамгийн өргөн эрх мэдэлтэй БНУ. Өнөөгийн ОХУ-ын улс төрийн систем нь хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан бараг бүх БНУ-уудад давтагдаж байгаа систем.

Хэдийгээр Монгол, Оросын хооронд стратегийн түншлэлийн талаархи гэрээ хэлэлцээрийн баримт бичгүүд нь бүгд хууль эрх зүйн чадамжтай байсан хэдий ч энэхүү судалгаагаар аливаа гэрээ, хэлэлцээрийн легитимность нь хэр вэ гэдэг онцгой анхаарах нь чухал гэсэн дүгнэлт хийж байна. Нэн ялангуяа, улс төр, эдийн засгийн чадавхи сул орнуудад энэ нь онцгой чухал бөлгөө.

### **ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ**

<sup>1</sup> Ц.Майдар. Нэн шинэхэн түүх. 1991, УБ., х.32-41

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Монгол-Оросын харилцаа баримт бичиг 1991-2004. УБ., 2006. Т.24.

<sup>4</sup> [www.ges.gov.mn](http://www.ges.gov.mn)

<sup>5</sup> ОУС, 2002 он, дугаар 2.

<sup>6</sup> Монгол-Оросын харилцаа баримт бичиг 1991-2004. УБ., 2006. Т.24-28

<sup>7</sup> [www.ges.gov.mn](http://www.ges.gov.mn)

<sup>8</sup> “Монгол улс зах зээлд” статистикийн эмхэтгэл, 1989-2002он, хуудас 92-229,

<sup>9</sup> на официальном сайте Банка России <http://www.cbr.ru>

<sup>10</sup> Восток и Россия: взгляд из Сибири. Материалы и тез. докл. к науч.-практ. Конф.-Иркутск, 2002. №105-116.

<sup>11</sup> Монгол-Оросын харилцаа баримт бичиг 1991-2004. УБ., 2006. Т.160 -166

<sup>12</sup> [www.mongolia.mid.ru](http://www.mongolia.mid.ru)

<sup>13</sup> [www.ges.gov.mn](http://www.ges.gov.mn)

<sup>14</sup> Үндэсний статистикийн хорооны эмхэтгэл. 2012 он, хуудас 126-182.

<sup>15</sup> на официальном сайте Банка России <http://www.cbr.ru>

<sup>16</sup> 14.11.2000 9:44 | РБК

**Abstract:**

This research work considers detailed investigation of the following four important documents, which were signed between Mongolia and Russia after 1991. These are "The declaration of friendship and cooperation", "The agreement of friendship, cooperation and neighbourly relationship between Mongolia and Russia", "The declaration of Ulaanbaatar", "The declaration of Moscow". The research briefly compares economic and political environment in both countries during times when these documents were formed. Furthermore, this research work evaluates these important documents which play a profound role in strategic partnership between Russia and Mongolia.

**Keywords:** Mongolia, Russia, Declaration of Ulaanbaatar, Declaration of Moscow, Mongolian and Russian agreement of 1993, Declaration of friendship and cooperation between Mongolia and Russia.